



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

СҮХБААТАР ДҮҮРГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН 2024 ОНЫ  
САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН  
ТАЙЛАН

АУДИТЫН КОД: НТАГ-2025/407/НА-СТА-ТШ3

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг  
дараах хаягаар авна уу.



Нийслэл дэх Төрийн аудитын газрын дэд дарга: Ч.Болд  
Утас: 70007734 Цахим хаяг: boldch@audit.gov.mn

Санхүү-нийцлийн аудитын хэлтсийн дарга: Х.Түвшинбаяр

Утас: 315558 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn

Аудитын менежер: Я.Алтанцэцэг

Утас: 325093 Цахим хаяг: altantsetsegya@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Солид Юнити Аудит ХХК-ийн  
захирал: Э.Мөнхтогтох

Утас: 99063227 Цахим хаяг: munkhtogtokh.e@solidunity.mn

## АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ .....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	8
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	11
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан .....	13
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА .....	14
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа .....	14
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин .....	14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	15
3.4 Нягтлан бodoх бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд.....	15
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	16
4. АУДИТИН ТАЙЛАН .....	18
4.1 Ерөнхий зүйл.....	18
4.2 Материаллаг байдал .....	18
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .....	18
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	19
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	20
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	20
5. АУДИТИН ИЛРҮҮЛЭЛТ .....	21
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ .....	23

### Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗГНХөрөнгө	Засгийн газрын нөөц хөрөнгө
ЗГСНХ	Засгийн газрын нөөц сангийн хөрөнгө
НДЕГ	Нийгмийн Даатгалын Ерөнхий Газар
НТАГ	Нийслэл дэх төрийн аудитын газар
ТБОНӨХБАУХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
ТӨБЗГ	Төрийн Өмчийн Бодлого Зохицуулалтын Газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон улсын Стандарт
ҮОМШӨ	Үйлдвэрийн осол мэргэжлээс шалтгаалах өвчин



**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
НИЙСЛЭЛ ДЭХ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,  
ГАмарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,  
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54

И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2025. 04. 25 № 01/69  
таний -ны № -т

**СҮХБААТАР ДҮҮРГИЙН  
НИЙГМИЙН ДААТГАЛЫН  
ГАЗРЫН ДАРГА Б.ЭНХТӨР  
ТАНАА**

### **Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сүхбаатар дүүргийн нийгмийн даатгалын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

### **Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглувансан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### **Асуудлыг онцолсон хэсэг**

Тайланда онд мөрдөгдөж өхэлсэн нийгмийн даатгалын ерөнхий хуулийн шинэчлэлээр нийгмийн даатгалын хэлтэс нь нийгмийн даатгалын газар болж нийгмийн даатгалын тогтолцоонд өөрчлөлт орсон. Уг өөрчлөлттэй холбоотой цалингийн шатлал шинэчлэгдэж, улсын төсвөөс санхүүжиж байна. Мөн нийгмийн даатгалын сангийн тайлантай үйл ажиллагааны санхүүгийн тайланг нэгтгэж тайлагнадаг байсан нь өөрчлөгдөж тус нь тайлагнадаг болсон.

### **Аудитын гол асуудал**

Байгууллагын үйл ажиллагаанд ашиглаж буй санхүүгийн программаас бараа материалын тайлан алдаатай, цалингийн журнал бичилт зөрүүтэй бэлтгэгдэж байгаа нь мэдээлэл хэрэглэгчдийг үнэн зөв, бүрэн мэдээллээр хангахгүй байгаа хэдий ч уг мэдээллийн зөрүүтэй байдлын дүн нь материаллаг бус, хараат бус аудиторын дүгнэлтэд нөлөөлөхгүй гэж үзсэн.

### **Бусад асуудал**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилтын хүрээнд 46 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж 91.3 хувийн хэрэгжилттэй гэж тайлагнасан байна

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бodoх бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бodoх бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагаын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР



М.ЭРДЭНЭЖАРГАЛ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>39,116,029.00</b>	<b>84,143,936.00</b>
34	Урьдчилгаа	-	<b>1,500,000.00</b>
34600	Урьдчилж гарсан зардал	-	1,500,000.00
35	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>39,116,029.00</b>	<b>82,643,936.00</b>
354	<b>Хангамжийн материал</b>	<b>39,116,029.00</b>	<b>82,643,936.00</b>
35410	Бичиг хэргийн материал	4,441,640.00	7,496,040.00
35420	Аж ахуйн материал	21,341,300.00	25,217,307.00
35430	Сэлбэг хэрэгсэл	11,026,090.00	45,604,390.00
35450	Барилгын засварын материал	-	442,800.00
35470	Бусад хангамжийн материал	2,306,999.00	3,883,399.00
2	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,749,696,279.85</b>	<b>1,731,627,772.26</b>
39	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>1,749,696,279.85</b>	<b>1,731,627,772.26</b>
392	<b>Биет хөрөнгө</b>	<b>1,728,098,819.85</b>	<b>1,710,030,312.26</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,834,508,186.00	1,834,508,186.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(221,033,191.26)	(252,086,919.66)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	12,210,000.00	12,210,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(4,884,000.00)	(7,326,000.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	130,031,349.00	175,084,149.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(48,261,952.46)	(74,841,923.51)
39207	Тавилга, аж ахуйн эд хопшил	122,499,705.02	120,647,760.99
39208	Хуримтлагдсан элэгдэл	(96,971,276.45)	(98,164,940.56)
393	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>21,597,460.00</b>	<b>21,597,460.00</b>
39303	Бусад биет бус хөрөнгө	21,597,460.00	21,597,460.00
3	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>1,788,812,308.85</b>	<b>1,815,771,708.26</b>
4	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	-	6,110,950.96
41	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	-	6,110,950.96
413	<b>Өглөг</b>	-	6,110,950.96
41361	Байгууллагад төлөх өглөг	-	6,110,950.96
5	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,788,812,308.85</b>	<b>1,809,660,757.30</b>
51	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>1,788,812,308.85</b>	<b>1,809,660,757.30</b>
51100	Засгийн газрын оруулсан капитал	611,489,291.11	611,489,291.11
512	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>1,177,323,017.74</b>	<b>1,198,171,466.19</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	1,177,323,017.74	1,171,212,066.78
51220	Тайлант үеийн үр дүн	-	26,959,399.41
6	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>1,788,812,308.85</b>	<b>1,815,771,708.26</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,850,146,870.27	2,630,212,355.97
12	Татварын бус орлого	4,634,430.27	20,529,555.97
120	Нийтлэг татварын бус орлого	4,634,430.27	20,529,555.97
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	4,634,430.27	20,529,555.97
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	4,316,440.27	17,662,355.97
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	317,990.00	2,867,200.00
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,845,512,440.00</b>	<b>2,609,682,800.00</b>
	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	-	<b>45,875,000.00</b>
131103	ЗГНХ, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	38,536,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	7,339,000.00
1310	<b>Улсын төсвөөс</b>	-	2,563,807,800.00
131001	Ургал үйл ажиллагааны санхүүжилт	-	2,563,807,800.00
1330	<b>Төсвийн захирагчдаас</b>	<b>5,807,740.00</b>	-
133002	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,807,740.00	-
1340	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	<b>1,839,704,700.00</b>	-
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	1,839,704,700.00	-
2	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,889,763,979.83</b>	<b>2,603,252,956.56</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,889,763,979.83</b>	<b>2,603,252,956.56</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,736,218,631.13</b>	<b>2,445,834,304.62</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>1,345,913,497.82</b>	<b>2,011,049,644.89</b>
210101	Үндсэн цалин	784,524,822.89	1,033,198,401.85
210102	Нэмэгдэл	273,527,604.31	461,981,443.43
210103	Унаа хоолны хөнгөлөлт	140,135,672.91	253,939,459.57
210104	Урамшуулал	147,725,397.71	261,930,340.04
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>206,513,876.42</b>	<b>245,113,374.24</b>
210201	Тэтгэврийн даатгал	142,353,116.67	181,244,745.31
210202	Тэтгэмжийн даатгал	16,598,026.93	18,673,600.18
210203	ҮОМШӨ-ний даатгал	13,165,521.42	8,378,933.29
210204	Ажилгүйдлийн даатгал	3,118,090.89	7,272,217.17
210205	Эрүүл мэндийн даатгал	31,279,120.51	29,543,878.29
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>39,792,693.44</b>	<b>34,470,442.75</b>
210301	Гэрэл, цахилгаан	19,354,600.00	15,086,232.27
210302	Түлш, халаалт	12,761,876.70	10,774,681.34
210303	Цэвэр, бохир ус	7,676,216.74	8,609,529.14

**Сүхбаатар дүүргийн нийгмийн даатгалын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

<b>Дансны код</b>	<b>Үзүүлэлт</b>	<b>Өмнөх оны гүйцэтгэл</b>	<b>Тайлант оны гүйцэтгэл</b>
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>31,912,059.62</b>	<b>38,354,054.18</b>
210401	Бичиг хэрэг	15,669,580.00	22,680,453.00
210402	Тээвэр, шатахуун	1,185,700.00	-
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,548,312.62	9,703,818.18
210405	Хог хаягдал зайлцуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,180,000.00	1,200,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,815,690.00	4,769,783.00
210408	Бараа материал акталсны зардал	512,777.00	-
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>12,237,750.00</b>	<b>22,815,300.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	2,290,000.00
210604	Урсгал засвар	12,237,750.00	20,525,300.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>30,424,211.00</b>	<b>19,954,125.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,420,200.00	1,700,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	5,700,000.00	13,700,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	569,100.00	586,920.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	59,984.00	79,984.00
210807	Газрын төлбөр	94,047.00	194,121.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	19,583,100.00	2,786,300.00
210809	Улсын мэдээллийн маятт хэвлэх, бэлтгэх	997,780.00	906,800.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>69,424,542.83</b>	<b>74,077,363.56</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	275,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,850,000.00	2,770,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	66,574,542.83	71,032,363.56
<b>213</b>	<b>ҮРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>153,545,348.70</b>	<b>157,418,651.94</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>122,982,123.00</b>	<b>63,955,789.80</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	11,818,368.00	25,787,087.80
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	111,163,755.00	38,168,702.00
2133	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	-	<b>93,462,862.14</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	93,462,862.14
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>30,563,225.70</b>	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	30,563,225.70	-
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>(39,617,109.56)</b>	<b>26,959,399.41</b>
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН</b>	<b>(39,617,109.56)</b>	<b>26,959,399.41</b>

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	2,388,425,879.87	2,609,682,800.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	548,721,179.87	-
120	Нийтлэг татварын бус орлого	548,721,179.87	-
120009	Бусад орлого	548,721,179.87	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,839,704,700.00	2,609,682,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	45,875,000.00
131103	ЗГНХ, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	38,536,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	7,339,000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	-	2,563,807,800.00
131001	Ургал үйл ажиллагааны санхүүжилт	-	2,563,807,800.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	1,839,704,700.00	-
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	1,839,704,700.00	-
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	2,388,180,341.70	2,574,381,300.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,388,180,341.70	2,574,381,300.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,234,864,893.00	2,416,962,648.06
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,345,913,497.82	2,011,049,644.89
210101	Үндсэн цалин	766,463,956.52	1,033,198,401.85
210102	Нэмэгдэл	272,181,767.80	461,981,443.43
210103	Унаа хоолны хөнгөлөлт	165,774,133.58	253,939,459.57
210104	Урамшуулал	141,493,639.92	261,930,340.04
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	206,513,876.42	245,113,374.24
210201	Тэтгэврийн даатгал	140,917,787.02	181,244,745.31
210202	Тэтгэмжийн даатгал	16,598,026.93	18,673,600.18
210203	ҮОМШӨ-ний даатгал	13,238,421.84	8,378,933.29
210204	Ажилгүйдлийн даатгал	3,243,775.93	7,272,217.17
210205	Эрүүл мэндийн даатгал	32,515,864.70	29,543,878.29
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	39,792,693.44	34,470,442.75
210301	Гэрэл, цахилгаан	19,354,600.00	15,086,232.27
210302	Түлш, халаалт	12,761,876.70	10,774,681.34
210303	Цэвэр, бохир ус	7,676,216.74	8,609,529.14

Сүхбаатар дүүргийн нийгмийн даатгалын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд  
хийсэн аудитын тайлан

Дансны код	Үзүүлэлт	Тайлант оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>41,417,002.62</b>	<b>41,200,461.18</b>
210401	Бичиг хэрэг	14,970,490.00	22,034,853.00
210402	Тээвэр, шатахуун	1,185,700.00	-
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,548,312.62	9,703,818.18
210405	Хог хаягдал зайлцуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,180,000.00	1,200,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	18,532,500.00	8,261,790.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>19,745,850.00</b>	<b>59,336,400.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	7,508,100.00	38,368,300.00
210604	Урсгал засвар	12,237,750.00	20,968,100.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>37,466,811.00</b>	<b>22,747,325.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,920,200.00	5,400,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	5,700,000.00	13,700,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	569,100.00	586,920.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	59,984.00	79,984.00
210807	Газрын төлбөр	94,047.00	194,121.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	27,123,480.00	2,786,300.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>551,571,179.87</b>	<b>3,045,000.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	548,721,179.87	275,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,850,000.00	2,770,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>153,315,448.70</b>	<b>157,418,651.94</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>122,982,123.00</b>	<b>63,955,789.80</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулалт	11,818,368.00	25,787,087.80
213209	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	111,163,755.00	38,168,702.00
2135	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	-	<b>93,462,862.14</b>
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	93,462,862.14
<b>2133</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>30,333,325.70</b>	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	30,333,325.70	-
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>245,538.17</b>	<b>35,301,500.00</b>
<b>8</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДАЛ</b>	-	<b>35,301,500.00</b>
	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	-	<b>35,301,500.00</b>
	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	-	<b>35,301,500.00</b>
	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	35,301,500.00
<b>9</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	-	<b>(35,301,500.00)</b>
<b>10</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>245,538.17</b>	-

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	<b>2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>611,489,291.11</b>	<b>1,216,940,127.30</b>	<b>1,828,429,418.41</b>
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-
C03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>611,489,291.11</b>	<b>1,216,940,127.30</b>	<b>1,828,429,418.41</b>
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн бууралт	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	(39,617,109.56)	(39,617,109.56)
C08	<b>2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>611,489,291.11</b>	<b>1,177,323,017.74</b>	<b>1,788,812,308.85</b>
D01	<b>2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	<b>611,489,291.11</b>	<b>1,177,323,017.74</b>	<b>1,788,812,308.85</b>
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	(6,110,950.96)	(6,110,950.96)
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>611,489,291.11</b>	<b>1,171,212,066.78</b>	<b>1,782,701,357.89</b>
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн бууралт	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	26,959,399.41	26,959,399.41
D09	<b>2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>611,489,291.11</b>	<b>1,198,171,466.19</b>	<b>1,809,660,757.30</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	<b>НИЙТ ДҮН</b>				
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	2,563,807,800.00	2,470,344,937.86	93,462,862.14	<b>96%</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	2,563,807,800.00	2,470,344,937.86	93,462,862.14	<b>96%</b>
210	<b>БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	2,499,188,800.00	2,406,389,148.06	92,799,651.94	<b>96%</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	2,077,838,300.00	2,011,049,644.89	66,788,655.11	<b>97%</b>
210101	Үндсэн цалин	1,102,444,100.00	1,033,198,401.85	69,245,698.15	94%
210102	Нэмэгдэл	457,162,700.00	461,981,443.43	(4,818,743.43)	101%
210103	Унаа хоолны хөнгөлөлт	267,436,000.00	253,939,459.57	13,496,540.43	95%
210104	Урамшуулал	250,795,500.00	261,930,340.04	(11,134,840.04)	104%
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	268,729,800.00	245,113,374.24	23,616,425.76	<b>91%</b>
210201	Тэтгэврийн даатгал	184,336,300.00	181,244,745.31	3,091,554.69	98%
210202	Тэтгэмжийн даатгал	21,098,400.00	18,673,600.18	2,424,799.82	89%
210203	ҮОМШӨ-ний даатгал	10,549,200.00	8,378,933.29	2,170,266.71	79%
210204	Ажилгүйдлийн даатгал	10,549,200.00	7,272,217.17	3,276,982.83	69%
210205	Эрүүл мэндийн даатгал	42,196,700.00	29,543,878.29	12,652,821.71	70%
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	34,482,000.00	34,470,442.75	11,557.25	<b>100%</b>
210301	Гэрэл, цахилгаан	15,086,600.00	15,086,232.27	367.73	100%
210302	Тулш, халаалт	10,775,500.00	10,774,681.34	818.66	100%
210303	Цэвэр, бохир ус	8,619,900.00	8,609,529.14	10,370.86	100%
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	42,528,200.00	41,165,461.18	1,362,738.82	<b>97%</b>
210401	Бичиг хэрэг	22,000,000.00	21,999,853.00	147.00	100%
210402	Тээвэр, шатахуун	1,079,300.00	-	1,079,300.00	0%
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	9,952,100.00	9,703,818.18	248,281.82	98%
210405	Хог хаягдал зайлцуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,235,000.00	1,200,000.00	35,000.00	97%
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,261,800.00	8,261,790.00	10.00	100%
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>48,850,600.00</b>	<b>48,797,900.00</b>	<b>52,700.00</b>	<b>100%</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	35,150,600.00	35,133,800.00	16,800.00	100%
210604	Урсгал засвар	13,700,000.00	13,664,100.00	35,900.00	100%
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>365,000.00</b>	-	<b>365,000.00</b>	<b>0%</b>
210702	Дотоод албан томилолт	365,000.00	-	365,000.00	0%

**Сүхбаатар дүүргийн нийгмийн даатгалын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

Код	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>23,324,100.00</b>	<b>22,747,325.00</b>	<b>576,775.00</b>	<b>98%</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,484,800.00	5,400,000.00	84,800.00	98%
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	13,772,000.00	13,700,000.00	72,000.00	99%
210803	Даатгалын үйлчилгээ	784,800.00	586,920.00	197,880.00	75%
210804	Тээврийн хэрэгслийн татвар	98,100.00	79,984.00	18,116.00	82%
210807	Газрын төлбөр	398,100.00	194,121.00	203,979.00	49%
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	2,786,300.00	2,786,300.00	-	100%
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>3,070,800.00</b>	<b>3,045,000.00</b>	<b>25,800.00</b>	<b>99%</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	275,000.00	275,000.00	-	100%
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,795,800.00	2,770,000.00	25,800.00	99%
	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>64,619,000.00</b>	<b>63,955,789.80</b>	<b>663,210.20</b>	<b>99%</b>
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>64,619,000.00</b>	<b>63,955,789.80</b>	<b>663,210.20</b>	<b>99%</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулалт	26,146,800.00	25,787,087.80	359,712.20	99%
213207	Тэтгэврт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	38,472,200.00	38,168,702.00	303,498.00	99%
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>2,563,807,800.00</b>	<b>2,470,344,937.86</b>	<b>93,462,862.14</b>	<b>96%</b>
1310	<b>Улсын төсвөөс санхүүжих</b>	2,563,807,800.00	2,470,344,937.86	93,462,862.14	96%
131001	Улсын төсвөөс санхүүжих	2,563,807,800.00	2,470,344,937.86	93,462,862.14	96%
	<b>Төсвийн бусад мэдээллийн ангилал</b>	121.00	115.00	6.00	95%
	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	1.00	1.00	-	100%
	Төсвийн байгууллага	1.00	1.00	-	100%
	<b>АЖИЛЛАГСАД БҮГД</b>	60.00	57.00	3.00	95%
	Удирдах ажилтан	6.00	1.00	5.00	17%
	Гүйцэтгэх ажилтан	51.00	54.00	(3.00)	106%
	Үйлчлэх ажилтан	3.00	2.00	1.00	67%
	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	60.00	57.00	3.00	95%
	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	48.00	43.00	5.00	90%
	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (TY)	12.00	14.00	(2.00)	117%

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Тайлант он
1	ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГО	45,875,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	45,875,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	45,875,000.00
131103	ЗГНХ, ЗДНХөрөнгө түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	38,536,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	7,339,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	37,275,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	37,275,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	37,275,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	35,000.00
210401	Бичиг хэрэг	35,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	37,240,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	29,936,000.00
210604	Урсгал засвар	7,304,000.00
3	ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	8,600,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДАЛ	8,600,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	8,600,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	8,600,000.00
225101	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	8,600,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(8,600,000.00)

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сүхбаатар дүүргийн нийгмийн даатгалын газар нь “Бид даатгуулагчийнхаа итгэл найдвар, сэтгэл ханамжаар үнэлэгдэх нийгмийн даатгалын үйлчилгээг хүргэнэ” гэсэн эрхэм зорилгын хүрээнд “Нийгмийн даатгалын байгууллага нь өсөн дэвших эрмэлзэлтэй мэргэшсэн, чадварлаг, ёс зүйтэй хүний нөөцөд түшиглэн үйл ажиллагаагаа цаг үргэлжид сайжруулан, түншлэл хамтын ажиллагааг дэмжин, харилцан үр ашигтай хамtran ажиллаж, сайн засаглалыг хэрэгжүүлэн, хэрэгцээ шаардлагад нийцсэн чанартай үйлчилгээг даатгуулагчдад хүргэнэ” гэсэн чанарын бодлого баримтлан үйл ажиллагаагаа явуулж байна.

Ажил олгогч, даатгуулагчийн төлсөн шимтгэл болон хуульд заасан бусад эх үүсвэрээр нийгмийн даатгалын сангийн хөрөнгийг бүрдүүлж, даатгуулагчдад тэтгэвэр, тэтгэмж төлбөр олгох үйл ажиллагаа эрхэлдэг байгууллага юм.

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Сүхбаатар дүүргийн нийгмийн даатгалын газар нь нийгмийн даатгалын ерөнхий хууль, Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бodoх бүртгэлийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Татварын багц хуулиуд, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоолууд болон бусад холбогдох хууль, тогтоомжид нийцүүлэн үйл ажиллагаагаа явуулж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бodoх бүртгэлд мөрддөг дараах хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Нийгмийн даатгалын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль /шинэчилсэн найруулга/;
- Засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 469 дүгээр тогтоол “Нийгмийн даатгалын байгууллагын дүрэм”;
- Засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 470 дугаар тогтоол “Нийгмийн даатгалын шимтгэл төлөх журам”.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллага нь дотоод аудитын тасгийн дарга дотоод аудитор, хяналтын 9 байцаагч нийт 11 орон тоотой. Дотоод аудит нь нийгмийн даатгалын шимтгэл ногдуулалт, тэтгэвэр, тэтгэмж тогтоолттой холбоотой зөрчил дутагдлыг илрүүлэх, үйл явцыг үнэлж, дүгнэх үйл ажиллагаа явуулдаг. Тухайлбал ажилгүйдлийн тэтгэмж, хөдөлмөрийн чадвар түр алдсаны, жирэмсэн амаржсаны тэтгэмжийн болон эмнэлгийн хуудасны бичилт, тэтгэмжийн бодолт, олголтын тооцоо зөв хийгдсэн эсэхийг үнэлж шалгадаг. Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сүхбаатар дүүргийн нийгмийн даатгалын газар нь 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2022 оны А/64, А/65 дугаар тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг санхүүгийн үйл ажиллагаандaa мөрдөж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Сүхбаатар дүүргийн нийгмийн даатгалын газар нь 2024 оны санхүүгийн тайланг 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэсэн байна..

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 26,959.4 мянган төгрөгөөр буюу 2.0 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Урьдчилж төлсөн төлбөр	-	1,500.0	1,500.0
Бараа материал	39,116.0	82,643.9	43,527.9
Үндсэн хөрөнгө	1,749,696.3	1,731,627.8	(18,068.50)
<b>Нийт хөрөнгийн дүн</b>	<b>1,788,812.3</b>	<b>1,815,771.7</b>	<b>26,959.4</b>
Богино хугацаат өр төлбөр	-	6,111.0	6,111.0
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,788,812.3	1,809,660.8	20,848.4
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>1,788,812.3</b>	<b>1,815,771.7</b>	<b>26,959.4</b>

Дээрх хүснэгтээс харахад өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр, эздийн өмч данснууд байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 82,643.9 мянган төгрөг болж 43,527.9 мянган төгрөгөөр өссөн нь тайлант хугацаанд худалдан авалт хийсэн үйл ажиллагаанд ашиглагдах хангамжийн шинжтэй аж ахуйн материал, сэлбэг хэрэгслийн материалын өсөлт нөлөөлсөн байна. Байгууллагын үйл ажиллагаандаа ашигладаг бараа материалын үлдэгдлийн 55.2 хувийг багаж, сэлбэг хэрэгсэл, 29.4 хувийг аж ахуйн материал, 9.1 хувийг бичиг хэргийн материал, 6.3 хувийг хангамжийн болон бусад материал тус тус эзэлж байна.

Бараа материалын дансны үлдэгдэлд ашиглалтгүй байгаа болон их хэмжээгээр худалдан авч нөөцөлсөн материал байхгүй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,710,030.3 мянган төгрөг болж, 18,068.5 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд байгуулсан элэгдлийн зардалтай холбоотой байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар цэвэр хөрөнгө өмчийн дүн өмнөх оноос 20,848.4 мянган төгрөгөөр өссөн байна. Энэ нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 2,337,778.3 төгрөг, нийт зарлагыг 2,337,778.3 төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас зардлыг 141,341.5 мянган төгрөгөөр бууруулж, 2,196,436.8 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшууллын төсвийн төслийг бодитой, үндэслэлтэй тооцоолоогүйтэй холбоотой байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 367,371.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 8 арга хэмжээг санхүүжүүлэхээр 2,563,807.8 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр баталсан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 2,563,807.8 мянган төгрөг, нэмэлт санхүүжилтээр 45,875.0 мянган төгрөг, нийт 2,609,682.8 мянган төгрөгийн санхүүжилт олгож, үндсэн үйл ажиллагааны зардалд 2,516,219.9. мянган төгрөгийг зарцуулан, зарцуулаагүй үлдэгдэл 93,462.9 мянган төгрөгийг улсын төсөвт буцааж төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,470,344.9 мянган төгрөг буюу 96.3 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлын төсвийг 66,788.6 мянган төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл, 23,616.4 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

**Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл**

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт /хувь/
1	80101-Үндсэн үйл ажиллагааны зардал	2,397,239.1	2,316,001.2	81,237.9	96.6
2	80103-Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил үйлчилгээ	31,580.0	21,462.9	10,117.1	68.0
3	80813-Өмгөөлөл, хуулийн зөвлөхийн үйлчилгээний хөлс	784.8	700.0	84.8	89.2
4	80219 Харуул, хамгаалалтын зардал	1,000.0	1,000.0	-	100.0
5	80224-Зөвлөл, хороо гишүүдийн ажлын хөлс	68,584.9	67,225.0	1,359.9	98.0
6	80802-Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	38,472.2	38,168.7	303.5	99.2
7	80813-Хуульд заасан үндэслэлээр албан хаагчид олгох нөхөн олговор	2,746.8	2,572.1	174.7	93.6
8	80820-Бусад тусламж дэмжлэг	23,400.0	23,215.0	185.0	99.2
	<b>Нийт</b>	<b>2,563,807.8</b>	<b>2,470,344.9</b>	<b>93,462.9</b>	<b>96.4</b>

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд ЗГНХ, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгөөс 38,536.0 мянган төгрөг, Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгөнөөс 7,339.0 мянган төгрөг, нийт 45,875.0 мянган төгрөгийн орлого олж, 45,875.0 мянган төгрөгийг зарцуулжээ. Зарцуулалтыг дэлгэрэнгүй харуулахад:

- Хангамж, бараа материалын зардалд 35.0 мянган төгрөг;
- Эд хогшил, урсгал засварын зардалд 37,240.0 мянган төгрөг;
- Биет хөрөнгө худалдан авсан зардалд 8,600.0 мянган төгрөг тус тус байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Худалдан авах ажиллагааг нийслэлийн нийгмийн даатгалын газар зохион байгуулан явуулдаг. Тайлант онд нэмэлт санхүүжилтээр засаг даргын нөөц хөрөнгөөр 45,875.0 мянган төгрөгийн архивын зориулалттай хөрөнгийг нээлттэй сонгон шалгаруулалтаар худалдан авсан.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сүхбаатар дүүргийн нийгмийн даатгалын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланда аудит хийсэн байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах нягтлан бодох бүртгэлийг үнэн зөв бүртгэх, түүнд тавих хяналтыг сайжруулах, санхүүгийн программ хангамж дээр гарч буй алдааг засварлах зэрэг зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Солид Юнити Аудит ХХК-ийн аудитор Г.Нандинцэцэг, Ү.Цэцэгмаа, аудиторын туслах Э.Цэнддорж, Э.Мэндсайхан, Э.Хонгорзул нар гүйцэтгэж, чанарын хяналтыг хяналтын менежер Н.Тунгалаг, захирал Э.Мөнхтогтох, НТАГ-ын Санхүүнийцлийн аудитын хэлтсийн аудитын менежер Я.Алтанцэцэг, хэлтсийн дарга Х.Түвшинбаяр, дэд дарга Ч.Болд нар тус тус хэрэгжүүлсэн.

Сүхбаатар дүүргийн нийгмийн даатгалын газар нь 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг 2025 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 70 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны бараа ажил үйлчилгээний зардлын 1,743,759.0 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 17,437.6 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуульд заасан хангамж болон үйл ажиллагаанд тавих хязгаарлалт, хэмнэлтийн горимыг мөрдөж ажилласан эсэхийг шалгахад дэд дарга, орлогч дарга, зөвлөхийн албан тушаалын орон тоогүй, дуудлагын автомашин ашиглаагүй, хуулийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажилласан байна. Тус байгууллага нь тайлант хугацаанд 68,393.7 мянган төгрөгийн цахим дэлгүүрт байршсан барааг бусад этгээдээс худалдан авсан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-д "Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно" гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Ерөнхий гэрээний дагуу цахим дэлгүүрээс худалдан авах бараа, ажил үйлчилгээг цахим дэлгүүрээс худалдан авч байх зөвлөмж хүргүүлэв.

#### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Сүхбаатар дүүргийн нийгмийн даатгалын газар нь 2024 онд нийт 143,463.9 мянган төгрөгийн 13 худалдан авалтын мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 57,806.3 мянган төгрөгийн 5 мэдээллийг ил тод байршуулаагүй байна. Үүнд:

Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст 57,806.3 мянган төгрөгийн 5 харилцагчийн худалдан авалтыг мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5-д "Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" долоо хоногийн дотор мэдээлнэ, мөн хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-д "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэж заасантай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны мэдээллийг холбогдох хуульд заасан хугацаанд байршуулж ажиллах зөвлөмж өгөв.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

ТБОНӨХБАҮХАТ хууль, тогтоомжтой холбоотой хэрэгжилтийг түүвэрлэн үзэхэд материаллаг хэмжээний зөрчил илрээгүй болно.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай, цахим дэлгүүрт байршсан барааг бусад этгээдээс худалдан авсан нь Төрийн хэмнэлтийн хууль тогтоомжийн холбогдох заалттай тус тус нийцээгүй, бусад хууль тогтоомж болон төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд төсвийн зарцуулалт нь нийцсэн байна гэж дүгнэлээ.

#### 4.5 Завсрыйн аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрыйн аудитын талаар

Завсрыйн аудитаар шалгагдагч байгууллагын 2024 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланг хамруулж, мөнгөн хөрөнгө, бараа материал, үндсэн хөрөнгө, цалин, орлого, зардлын дансдын хувьд горим, сорил хэрэгжүүлсэн.

Аудитын илрүүлэлтийг шалгагдагч байгууллагад асуудлын бүртгэлээр танилцуулж, 14,669.9 мянган төгрөгийн 3 алдааг залруулсан.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 18,002.4 мянган төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 4 зөвлөмж өгснийг зөрчлийг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	4	18,002.4	4	18,002.4	100.0
Нийт дүн	4	18,002.4	4	18,002.4	100.0

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Сүхбаатар дүүргийн нийгмийн даатгалын газрын нягтлан бодох бүртгэлийн программ нь цалингийн журнал бичилтийг материаллаг хэмжээний биш боловч алдаатай бүртгэж байна. Иймээс дараагийн аудитаар программын сайжруулалт болон цалингийн журнал бичилтийн үнэн зөв болон холбогдох хяналтыг анхаарч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 59,472.3 мянган төгрөгийн алдаа<sup>1</sup> илэрснээс аудитын явцад залруулсан. Үүнд:

Залруулсан алдаа:

- Үндсэн хөрөнгийн шинжтэй нэг жилээс дээш хугацаанд ашиглагдах 6,770.9 мянган төгрөгийн хөрөнгийг бараа материалын дансанд орлогоор бүртгэсэн;
- Үндсэн хөрөнгийн тайлант жилийн 14,529.5 мянган төгрөгийн хуримтлагдсан элэгдэл, элэгдлийн зардлыг алдаатай буюу илүү тооцоолон бүртгэсэн;
- Нэг жилийн хугацаатай цахим архивын 5,125.0 мянган төгрөгийн түрээсийн төлбөрийг биет бус хөрөнгөөр бүртгэсэн ба зардлыг аккурэл сууриар бүртгээгүй;
- Бараа материалын тайланд 26,936.0 мянган төгрөгийн 47,782 ш чипийг орлогод авахдаа 2 ш-ээр буюу бөөн дүнгээр тоо хэмжээг зөрүүтэй бүртгэсэн;
- Өмнөх оны шүүхийн шийдвэрийн дагуу 6,110.9 мянган төгрөгийн өглөг бүртгэж, тайлант хугацааны зардал бүртгэсэн.

Аудитаар нийт 9,078.9 мянган төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрснээс, 9,078.9 мянган төгрөгийн 3 зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материалын тайлант түвшнээс 8,358.7 мянган төгрөгөөр бага тул Өөрчлөлтгүй дүгнэлт өглөө.

### 5.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Бараа материалын бүртгэл, тайлagnalтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Бараа материал бүртгэлийн бодлогоос зөрүүтэй бүртгэгдэж, бараа материалын дэлгэрэнгүй тайлан санхүүгийн программаас алдаатай бэлтгэгдэж байна. Тухайлбал, Нэг төрлийн бараа материалыг хэд хэдэн нэршлээр бүртгэсэн, товчоо тайлан бэлтгэгдээгүй, эхний үлдэгдлийн тоо хэмжээ тайлангаас харагдахгүй, үнийн дүн гүйлгээ балансын эхний үлдэгдлээс зөрүүтэй, мөн санхүүгийн байдлын тайланд 89 сая төгрөгийн бараа материал үлдэгдэлтэй боловч барааны материалын дэлгэрэнгүй тайланд үлдэгдэл илэрхийлэгдэхгүй байна.

Энэ нь Нягтлан бodoх бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-д "Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бodoх бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бodoх бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлagnalтын толилуулга батламж мэдэгдлийг хангахгүй байна.

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

**Өгсөн зөвлөмж:** Бараа материалын бүртгэл хөтлөлтөд тавих хяналтыг сайжруулж, барааны дэлгэрэнгүй тайланг үнэн зөв тайлагнаж ажиллах.

## 2. Цалин хөлстэй холбоотой асуудал

**Илрүүлэлт:** Цалингийн зардлын журналд гүйлгээнд холбогдоогүй 13.5 сая төгрөгийн 35 ш гүйлгээ бүртгэлтэй бөгөөд үүнтэй холбоотой үр дүнгийн тайланд цалингийн зардал 2.0 сая төгрөг, нийгмийн даатгалын зардал 1.2 сая төгрөгөөр илүү тайлагнагдсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Цалингийн тооцоолол, бүртгэл хөтлөлтөд тавих хяналтыг сайжруулж, нийгмийн даатгалын тайланд тайлагнасан дүнтэй тулган шалгаж байх.

## 3. Зардлын бүртгэлтэй холбоотой асуудал

**Илрүүлэлт** Тайлант онд хамаарахгүй тээврийн хэрэгслийн татвар, газрын төлбөр, аудитын төлбөр зэрэг зардлыг аккурэл сууриар бүртгээгүй нь нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6.1-д “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө” гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын “тасалбар болголт” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Зардлын бүртгэлийг аккруэл сууриар хөтлөх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2025 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс Запруулсаагүй		Зөвлөмж /Мянган төгрөгөөр/	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Үндсэн хөрөнгийн шинжтэй нэг жилээс дээш хугацаанд ашиглагдах хөрөнгийг бараа материалын дансанд орлоготой бүртгэсэн байна.	1	6,770.9					1	6,770.9		
Үндсэн хөрөнгийн тайлант жилийн хуримтлагдсан элэгдэл, эзэгдлийн зардлыг алдаатай буюу илүү тооцоолон бүртгэсэн.	1	14,529.5					1	14,529.5		
Нэг жилийн хугацаатай цахим архивын түрээсийн төлбөрийг биет бус хөрөнгөөр бүртгэсэн ба зардлыг аккурэл сууриар бүртгээгүй байна.	1	5,125.0					1	5,125.0		
Бараа материалын тайланд 47,782 ш чипийг орлогод авахдаа 2 ш-ээр буюу бөөн дунгээр тоо хэмжээг зөрүүтэй авсан.	1	26,936.0					1	26,936.0		
Өмнөх оны шүүхийн шийдвэрийн дагуу өглөг бүртгэж тайлант хугацааны зардал бүртгэсэн.	1	6,110.9					1	6,110.9		
<b>Дүн</b>	<b>5</b>	<b>59,472.3</b>	-	-	-	-	<b>5</b>	<b>59,472.3</b>	-	-

## Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил	Төлбөрийн акт	Үүнээс						Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
			Албан шаардлага			Зөвлөмж	Хариуцлага тооцуулах албан шаардлага			
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Албан тоо	тушаалтын тоо
Бараа материал бүртгэлийн бодлогос зөрүүтэй бүртгэдэж, бараа материалын дэлгэрэнгүй тайлан санхүүгийн программаас алдаатай бэлтгэлдэж байна.		1	-			1	-			
Цалингийн зардлын журналд Кт данс нь ямар дансанд холбогдсон нь тодорхойгүй 13.5 сая төгрөгийн 35 ш гүйлгээ бүртгэлтэй бөгөөд үүнтэй холбоотой үр дүнтүйн тайланц цалингийн зардал 2.0 сая төгрөгөөр, нийгмийн даатгалын зардал 1.2 сая төгрөгөөр илүү тайлантасан.		1	3,258.8			1	3,258.8			
Тайлант онд хамаарахгүй тээврийн хэрэгслийн татвар, газрын төлбөр, аудитын төлбөр зэрэг зардлыг аккурап суурин бүртгэлтэй.		1	5,820.1			1	5,820.1			
<b>Дүн</b>	<b>3</b>	<b>9,078.9</b>				<b>3</b>	<b>9,078.9</b>			

## Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга		Нийт зөрчил		Үүнээс			
		Тоо	Дүн	Албан шаардлага	Тоо	Дүн	/Мянган төгрөөр/
Шилтэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил							Зөвлөмж
Шилтэн дансны нэгдсэн цахим хуудаст 57,806,3 мянган төгрөгийн 5 харилцагчийн худалдан авалтыг мэдээлээгүй байна.	1	57,806.3			1		57,806.3
Дүн	1	<b>57,806.3</b>	-		-	1	<b>57,806.3</b>
Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилттэй холбоотой							
Цахим дэлгүүрт байршсан барааг бусад этгээдээс худалдан авсан	1	68,393.7			1		68,393.7
Дүн	1	<b>68,393.7</b>	-		-	1	<b>68,393.7</b>
Нийт дүн	2	<b>126,200.0</b>	0	0	2		<b>126,200.0</b>

ТЭМДЭГЛЭЛ